



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

д.д. 02.21 № 408

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ  
ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Х.ГАЛЫМБЕК ТАНАА

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх  
газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын  
тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 2... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХ-ОЧИР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.24 № 409  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН  
БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.ГАЛЫМБЕК  
ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\Documents\Documents\2020 oniywulaan bichig\2020.02.21.N-ABBTG.docx


002020270

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.МӨНХ-ОЧИР

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2020/263/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2020 он

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Ц.Бат-Өлзий  
Утас: 327734 Цахим хаяг: [bat-ulziits@audit.gov.mn](mailto:bat-ulziits@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Отгонбаяр  
Утас: 315558 Цахим хаяг: [otgonbayarda@audit.gov.mn](mailto:otgonbayarda@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Долгорсүрэн  
Утас: 325093 Цахим хаяг: [dolqorsureng@audit.gov.mn](mailto:dolqorsureng@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч

**Агуулга**

Аудитын гэрчилгээ.....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	13
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.21 № 409  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН  
БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.ГАЛЫМБЕК  
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

© Document Document 2020 01/04/2020 02:21:14 ABT0 600

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.МӨНХ-ОЧИР





## 2.1. Оршил

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Галымбек танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 21-нээс 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, НТАГ-ын ахлах аудитор Г.Долгорсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг НТАГ-т 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 01/64 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Эрхэм зорилго: Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар нь "Агаарын чанарыг тодорхойлох, агаарын бохирдолд хяналт, судалгаа шинжилгээ хийх, бохирдуулагч эх үүсвэрээс байгаль орчин, иргэдийн эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого шийдвэрийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах" эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар нь үйл ажиллагааны чиг үүргийг "Агаарын тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих; агаар бохирдуулах бодисын хаягдал, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийн тооллогыг мэргэжлийн албаны орон нутаг дахь салбартай хамтран нутаг дэвсгэртээ зохион байгуулах" гэж тодорхойлсон.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй.

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн

үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,879,738.6 мянган төгрөгөөс тооцон 97,594.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 152,002.9 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүн өмнөх оноос 55.7 хувиар нэмэгдсэнтэй холбоотой болно.

### 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,877,875.6 мянган төгрөгөөр буюу 261.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	489,148.3	203,565.3	(285,583.0)
Авлага	-	6,861,658.1	6,861,658.1
Урьдчилгаа	-	2,737,899.1	2,737,899.1
Бараа материал	341,483.3	265,063.0	(76,420.3)
Үндсэн хөрөнгө	2,569,727.8	2,210,049.4	(359,678.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,400,359.4</b>	<b>12,278,234.9</b>	<b>8,877,875.5</b>
Өр төлбөр	217,149.3	3,532,770.3	3,315,621.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,183,210.1	8,745,464.6	5,562,254.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,400,359.4</b>	<b>12,278,234.9</b>	<b>8,877,875.5</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад барьцаа данснаас Нийслэл дэх Төрийн аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актын 271,999.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн, 20,584.0 мянган төгрөгийн барьцаа чөлөөлсөн нь шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл өссөн нь нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 3,329,205.0 мянган төгрөгийг Нийслэлийн төрийн сангаас авах авлагаар бүртгэсэн, угаарын хий мэдрэгч худалдан авахтай холбоотой зардалд 3,532.453.1 мянган төгрөг урьдчилж төлсөн зэрэгтэй холбоотой.

Таван толгой түлш ХХК-д төлсөн сайжруулсан түлш борлуулагч нарын урамшуулал 1,602,374.7 мянга, шатахууны урьдчилгаа 420,000.0 мянга, түлш тээвэрлэх 8 ААН-д төлсөн 715,524.4 мянга, нийт 2,737,899.1 мянган төгрөгийг урьдчилгаа дансанд бүртгэсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд байгууллагын даргын шийдвэрээр 186,553.1 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой.

Тайлант онд 377,368.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал хуримтлуулан бүртгэж, үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан 6,757.4 мянга, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 11,545.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 5,555.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Сайжруулсан түлш тээвэрлэх тээврийн зардлын 3,222,805.0 мянга, хяналтын ажилтнуудын урамшууллын 106,400.0 мянга, нийт 3,329,205.0 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2017-2019 онуудын 203,565.3 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө, нийт өр төлбөрийн 5.8 хувийг эзэлж байна.

#### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нийслэлийн ИТХ-ын 2019 оны төсөв батлах тухай тогтоолд зааснаар Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар тайлант онд 10,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 23,046.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 130.5 хувиар биелүүлсэн.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 13,816,713.2 мянган төгрөг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,257,148.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 12,549,564.8 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 10,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд тус байгууллагын батлагдсан төсөв өмнөх оноос 12,964,767.1 мянган төгрөгөөр буюу 16.2 дахин нэмэгдсэн нь утаагүй Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд 13,149,564.8 мянган төгрөг төлөвлөсөнтэй холбоотой.

Хөрөнгө оруулалтаар Улаанбаатар төмөр замын зорчигчийн вагоны галлагааны зуухнаас гарах утааг бууруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэх, тоног төхөөрөмжийн 140,000.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 133,000.0 мянган төгрөгийг зарцуулж, барьцаа дансанд 7,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,354,769.0 мянган төгрөг буюу 31.5 хувьтай байгаа нь тээвэр шатахууны зардлаас 1,319,360.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил,

үйлчилгээний төлбөр хураамжаас 2,457,094.4 мянган төгрөгийг тайлант хугацаанд зарцуулалгүй орон нутгийн төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт санхүүжилтийн дансанд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 11,853,049.5 мянга, Нийслэлийн онцгой комиссоос 1,260.0 мянга, нийт 11,854,309.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс угаарын хий мэдрэгч худалдан авахтай холбоотой зардалд 3,525,600.0 мянга, сайжруулсан түлш тээвэрлэлтийн зардалд 2,837,195.0 мянга, хяналтын ажилтнуудын урамшуулалд 2,070,049.5 мянга, дата багцтай дугааруудын төлбөрт 22,000.0 мянга, түүхий нүүрсний эрхийн бичиг хэвлүүлэх зардалд 50,000.0 мянга, гэр байшингаа дулаалж, халаалтаа шинэ технологиор шийдсэн үлгэр жишээ айл өрхийн шагналд 19,000.0 мянга, комиссын хоолны зардалд 1,260.0 мянга, нийт 8,525,104.5 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 3,329,205.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

#### **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд 28 эрсдэл тогтоож, гүйцэтгэх үе шатанд шинээр эрсдэл нэмээгүй, нийт 26 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитын явцад угаарын хий мэдрэгч буюу нүүрстөрөгчийн дутуу исэл мэдэрч, сэрэмжлүүлэх төхөөрөмж худалдан авахдаа сонгон шалгаруулалт зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулсан, хяналтын ажилтнуудыг гадаад аялалд хамруулах буюу агаарын бохирдол бууруулахтай шууд хамааралгүй зардал санхүүжүүлсэн, санхүүгийн тайланд 3,329,205.0 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан боловч тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зэрэг асуудлаар үйлчлүүлэгч байгууллагаас тайлбар авч аудитын тайланд хавсаргав. Аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй.

#### **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тайлант хугацаанд 6,861,658.1 мянган төгрөгийн авлага, 2,737,899.1 мянган төгрөгийн урьдчилгаа, нийт 9,599,557.2 мянган төгрөгийг тооцооны дансанд тайлагнасан.

Тухайлбал, Таван толгой түлш ХХК-д сайжруулсан түлшний тээвэрлэлтийн зардалд 20,000.0 мянга, шатахууны зардалд 400,000.0 мянга, сайжруулсан түлш борлуулагчийн урамшуулалд 1,602,374.7 мянга, нийт 2,022,374.7 мянган төгрөг шилжүүлснийг урьдчилгаа дансанд тайлагнасан.

Мөн угаарын хий мэдрэгч буюу нүүрстөрөгчийн дутуу исэл мэдэрч, сэрэмжлүүлэх төхөөрөмж худалдан авахаар 3,512,953.1 мянган төгрөг шилжүүлсэн бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй байсан.

Иймд дээрх тооцооны дансаар хэрэгжсэн ажлын гүйцэтгэлийг дараагийн аудитаар шалгахаар тогтлоо.

#### **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 462 мэдээллийг хугацаанд нь байршуулсан.

#### 2.14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 271,999.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан.

#### 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### АУДИТЫН ТАЙЛАНГ


#### Хянасан:

Санхүүгийн аудитын хэлтсийн дарга  
бөгөөд аудитын менежер

Аудитын менежер

#### Бэлтгэсэн:

Ахлах аудитор



Ц.Бат-Өлзий

Д.Отгонбаяр

Г.Долгорсүрэн

Үйлчлүүлэгч байгууллагын хариу:



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АГААРЫН БОХИРДОЛТОЙ  
ТЭМЦЭХ ГАЗАР

Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011  
Утас: 31-46-76, Факс: (976-11) 32-46-32,  
E-mail: info@aprd.ub.gov.mn  
http://www.aprd.ub.gov.mn

2020.02.21 № 02/120  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАРТ

Тайлбар гаргах тухай

Тус газрын 2019 оны санхүүгийн тайлантай холбогдуулан дараах асуудалд тайлбар гаргаж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэлээр нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 2, 3 дугаар бүсэд орших айл өрхийг угаарын хий мэдрэгчээр хангах ажлыг зохион байгуулах үүрэг егөгдсөн. Энэхүү шийдвэрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/1245 дугаар захирамжаар угаарын хий худалдан авах гэрээ байгуулах эрхийг Улаанбаатар хотоос Эрэн хотод суугаа байнгын төлөөлөгчид үүрэг болгосноор БНХАУ-ын Гуандун мужийн Шэньжэнь хотын хамгаалалт, дохиололын технологийн "PGST" ХХК-тай PA-002W маркийн 200000 /хоёр зуун мянга/ угаарын хий мэдрэгч, сэрэмжлүүлэх төхөөрөмжийг худалдах, худалдан авах гэрээ байгуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/750 дугаарт "Хөрөнгө гаргах, эрх шилжүүлэх тухай" тушаалаар "Дотоод агаарын угаарын хий мэдрэгч төхөөрөмж"-ийг худалдан авахад зориулж 3,525,600,000.00 /гурван тэрбум таван зуун хорин таван сая зургаан зуун мянга/ төгрөгийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлсэн бөгөөд тус шилжин ирсэн төсвөөс санхүүжих ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/1289 дугаартай захирамжаар манай байгууллагад зөвшөөрсөн.

Нийслэлийн Засаг даргын А/1245 захирамжийн хүрээнд байгуулсан гэрээ, мөн Нийслэлийн Засаг даргын А/1289 захирамжаар олгосон зөвшөөрөл зэргийг тус тус үндэслэн угаарын хий мэдрэгч, сэрэмжлүүлэх төхөөрөмж худалдан авах 3,525,600,000.00 /гурван тэрбум таван зуун хорин таван сая зургаан зуун мянга/ төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/781 дугаартай "Хөрөнгө гаргах, эрх шилжүүлэх тухай" тушаал, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/1357 дугаартай захирамжаар нийслэлийн 6 дүүргийн агаарын чанарыг сайжруулах бүсэд хамрагдах 95 хороонд

D:\ABTG2020\Aiban bichig 02aafalban bichig A4.docx

ажиллаж буй орон тооны бус ажилтнуудыг урамшуулах ажлыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн хүрээнд зохион байгуулах үүрэг өгөгдсөн.

3. Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 19/05 дугаарт тогтоолоор тээвэрлэлтийн зардалд 6,060,000,000.00 /зургаан тэрбум жаран сая/ төгрөгийн санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарь, гэрээний дагуу Байгаль орчин аялал аялал жуулчлалын яамнаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлсэн.

Энэхүү санхүүжилтээс Нийслэлийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/865 дугаар захирамжийн дагуу сайжруулсан хатуу түлш тээвэрлэсэн 10 аж ахуйн нэгжид гэрээний дагуу тээврийн зардалд 2,837,195,000.00 /хоёр тэрбум найман зуун гучин долоон сая нэг зуун ерэн таван мянга/ төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зарцуулаагүй үлдэж, он дамжсан санхүүжилтийн үлдэгдэл болох 3,222,805,000.00 /гурван тэрбум хоёр зуун хорин хоёр сая найман зуун таван мянга/ төгрөг, мөн хяналтын ажилтнуудын урамшуулалд зарцуулах 106,400,000.00 /нэг зуун зургаан сая дөрвөн зуун мянга/ төгрөгийн санхүүжилт буюу нийт 3,329,205,000.00 /гурван тэрбум гурван зуун хорин есөн сая хоёр зуун таван мянга/ төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 2020 онд зарцуулах зөвшөөрөл авч Нийслэлийн төрийн сантай тооцоо нийлсэн болно.

Санхүүгийн тайлан гаргах хуулийн хугацаанд дээрх санхүүжилтийг олгох тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд төлөгдөх дүн нь баримтаар нотлогдохгүй, гүйцэтгэл нь тодорхойгүй, ирээдүйд үүсэх зайлшгүй богино хугацаат ер төлбөр юм.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ГАЛЫМБЕК



D:\BТГ2020\Alban bichig 02\aralban bichig A4.docx



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>830,631,541.60</b>	<b>10,068,185,519.60</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	489,148,268.00	203,565,310.00
3121	Төгрөг	489,148,268.00	203,565,310.00
31211	Төрийн сангийн харилцах	489,148,268.00	203,565,310.00
33	<b>АВЛАГА</b>		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	6,861,658,086.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	3,532,453,080.00
34	<b>УРЬДЧИЛГАА</b>		
34600	Урьдчилж гарсан зардал	-	2,737,899,078.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	341,483,273.60	265,063,045.60
351	Түүхий эд материал	-	4,856,890.00
35110	Тусгай зориулалттай материал	-	4,856,890.00
354	Хангамжийн материал	341,483,273.60	260,206,155.60
35410	Бичиг хэргийн материал	4,703,015.00	5,920,633.00
35420	Аж ахуйн материал	12,523,794.00	3,790,694.00
35430	Сэлбэг хэрэгсэл	300,161,868.60	220,966,731.60
35440	Түлш, шатах тослох материал	5,163,000.00	5,580,000.00
35470	Бусад хангамжийн материал	18,931,596.00	23,948,097.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,569,727,803.41</b>	<b>2,210,049,394.05</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,569,727,803.41	2,210,049,394.05
392	<b>Биет хөрөнгө</b>	732,172,565.44	412,375,561.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	260,636,840.00	260,636,840.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(184,886,840.00)	(213,386,840.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,297,970,521.00	3,310,597,972.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,669,883,480.67)	(2,972,534,556.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,817,830.00	35,117,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,982,305.09)	(20,605,553.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,463,200.00	37,463,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(22,963,199.80)	(24,913,199.74)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	1,837,555,237.97	1,797,673,832.18
39301	Програм хангамж	149,821,200.00	149,641,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(48,475,325.03)	(73,814,506.34)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,736,209,363.00	1,736,209,363.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(14,362,224.48)
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=II</b>	<b>3,400,359,345.01</b>	<b>12,278,234,913.65</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>217,149,268.00</b>	<b>3,532,770,316.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	217,149,268.00	3,532,770,316.00
413	Өглөг	217,149,268.00	3,532,770,316.00
4136	Бусад өглөг	217,149,268.00	3,532,770,316.00
41361	Байгууллагад төлөх өглөг	217,149,268.00	3,532,770,316.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,183,210,077.01</b>	<b>8,745,464,597.65</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,183,210,077.01	8,745,464,597.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,565,059,217.41	2,565,059,217.41
51101	Өмч: - төрийн	924,598,017.41	924,598,017.41
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	1,640,461,200.00	1,640,461,200.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	618,150,859.60	6,180,405,380.24
51210	Өмнөх үеийн үр дүн	3,669,847,950.34	618,150,859.60
51220	Тайлант үеийн үр дүн	(3,051,697,090.74)	5,562,254,520.64
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,400,359,345.01</b>	<b>12,278,234,913.65</b>

**4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,828,041,504.00</b>	<b>13,162,401,992.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>36,139,053.00</b>	<b>30,072,779.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,324,426.00	30,072,779.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	18,324,426.00	30,072,779.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,091,354.00	23,046,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	233,072.00	269,371.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	6,757,408.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	17,814,627.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	17,814,627.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,791,902,451.00</b>	<b>13,132,329,213.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	23,669,750.00	8,525,104,494.00
131103	ЭГНХ, ЭДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,669,750.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,525,104,494.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,768,232,701.00	4,467,224,719.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	808,978,350.00	1,257,148,400.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	-	3,210,076,319.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	959,254,351.00	-
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	140,000,000.00
133003	Хөрөнгийн	-	140,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,879,738,594.74</b>	<b>7,599,534,763.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,479,836,394.74</b>	<b>7,187,535,763.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,203,697,791.74	6,929,731,927.17
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	179,745,822.00	246,010,011.00
210101	Үндсэн цалин	140,771,982.00	199,666,450.00
210102	Нэмэгдэл	26,507,640.00	23,994,561.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,466,200.00	22,349,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,758,444.00	32,374,200.00
210201	Тэтгэврийн даатгал	16,376,371.00	22,532,167.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,962,517.00	2,651,407.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,445,215.00	1,975,207.00
210204	Ажилгүйдлийн даатгал	361,304.00	487,268.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,613,037.00	4,728,151.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,802,937.00	36,359,963.00
210301	Гэрэл, цахилгаан	11,974,937.00	11,431,963.00
210304	Байрны түрээс	24,828,000.00	24,928,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	126,759,246.00	3,220,570,797.00
210401	Бичиг хэрэг	5,075,400.00	6,566,832.00

**Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210402	Тээвэр, шатахуун	11,550,656.00	3,020,691,485.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,134,078.00	6,759,344.00
210408	Бараа материал акталсны зардал	103,999,112.00	186,553,136.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,923,202.00</b>	<b>54,909,943.08</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	379,905.00
210604	Урсгал засвар	13,923,202.00	54,530,038.08
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>388,500.00</b>	<b>1,186,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	388,500.00	1,186,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>193,419,154.00</b>	<b>2,958,652,189.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	191,681,380.00	2,953,660,873.00
210803	Даатгалын үйлчилгээ	310,814.00	3,985,656.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,700.00	540,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	1,124,260.00	366,660.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>628,900,486.74</b>	<b>379,668,824.09</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,764,162.00	1,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	75,000.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	547,061,324.74	377,368,824.09
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>25,830,000.00</b>	<b>120,093,600.00</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>-</b>	<b>120,093,600.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	120,093,600.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>25,830,000.00</b>	<b>-</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	25,830,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>250,308,603.00</b>	<b>137,710,235.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,159,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,159,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>248,308,603.00</b>	<b>135,551,235.92</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	248,308,603.00	135,551,235.92
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,399,902,200.00</b>	<b>411,999,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,399,902,200.00</b>	<b>411,999,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	3,399,902,200.00	411,999,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(3,051,697,090.74)</b>	<b>5,562,867,228.91</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>612,708.27</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	612,708.27
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(612,708.27)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(3,051,697,090.74)</b>	<b>5,562,254,520.64</b>

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,810,091,805.00</b>	<b>16,484,629,719.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,189,354.00</b>	<b>23,095,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,189,354.00	23,095,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	18,189,354.00	23,095,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,091,354.00	23,046,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	98,000.00	49,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,791,902,451.00</b>	<b>16,461,534,219.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	23,669,750.00	11,854,309,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,669,750.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,854,309,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	808,978,350.00	4,467,224,719.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	808,978,350.00	1,257,148,400.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	-	,210,076,319.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	959,254,351.00	140,000,000.00
133003	Хөрөнгийн	959,254,351.00	140,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>836,088,454.00</b>	<b>16,333,084,004.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>836,088,454.00</b>	<b>16,333,084,004.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>559,949,851.00</b>	<b>12,746,234,162.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	179,745,822.00	245,949,141.00
210101	Үндсэн цалин	145,612,622.00	198,481,122.00
210102	Нэмэгдэл	21,667,000.00	25,119,019.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,466,200.00	22,349,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,623,372.00	32,374,200.00
210201	Тэтгэврийн даатгал	16,376,371.00	23,050,848.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,962,517.00	2,471,204.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,310,143.00	1,846,405.00
210204	Ажилгүйдлийн даатгал	361,304.00	455,067.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,613,037.00	4,550,676.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,852,000.00	36,359,963.00
210301	Гэрэл, цахилгаан	12,024,000.00	11,431,963.00
210304	Байрны түрээс	24,828,000.00	24,928,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,801,084.00	4,170,499,679.00
210401	Бичиг хэрэг	6,477,850.00	7,184,450.00

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	12,865,656.00	4,156,555,885.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,457,578.00	6,759,344.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>79,357,001.00</b>	<b>112,053,943.08</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	486,799.00	1,042,305.00
210604	Урсгал засвар	78,870,202.00	111,011,638.08
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>388,500.00</b>	<b>1,186,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	388,500.00	1,186,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>179,796,694.00</b>	<b>4,619,951,236.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	178,790,180.00	4,614,959,920.00
210803	Даатгалын үйлчилгээ	310,814.00	3,985,656.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,700.00	540,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	393,000.00	366,660.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>34,385,378.00</b>	<b>3,527,860,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,310,378.00	3,526,860,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	75,000.00	1,000,000.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>25,830,000.00</b>	<b>120,093,600.00</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>-</b>	<b>120,093,600.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	120,093,600.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>25,830,000.00</b>	<b>-</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	25,830,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>250,308,603.00</b>	<b>3,466,756,241.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>248,308,603.00</b>	<b>3,464,756,241.92</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	248,308,603.00	135,551,235.92
213404	Хөрөнгийн	-	3,329,205,006.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>974,003,351.00</b>	<b>151,545,715.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,546,364,443.00</b>	<b>437,128,673.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,546,364,443.00</b>	<b>437,128,673.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,546,364,443.00</b>	<b>437,128,673.00</b>
223001	Бусад хөрөнгө	2,341,805,443.00	425,582,958.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	204,559,000.00	11,545,715.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(2,546,364,443.00)</b>	<b>(437,128,673.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(1,572,361,092.00)</b>	<b>(285,582,958.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,061,509,360.00</b>	<b>489,148,268.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>489,148,268.00</b>	<b>203,565,310.00</b>

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	924,598,017.41	3,669,847,950.34	4,594,445,967.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>924,598,017.41</b>	<b>3,669,847,950.34</b>	<b>4,594,445,967.75</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн	1,640,461,200.00	(3,051,697,090.74)	(1,411,235,890.74)
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,565,059,217.41</b>	<b>618,150,859.60</b>	<b>3,183,210,077.01</b>
<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>2,565,059,217.41</b>	<b>618,150,859.60</b>	<b>3,183,210,077.01</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,565,059,217.41</b>	<b>618,150,859.60</b>	<b>3,183,210,077.01</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	5,562,254,520.64	5,562,254,520.64
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,565,059,217.41</b>	<b>6,180,405,380.24</b>	<b>8,745,464,597.65</b>

**4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,816,713,200.00</b>	<b>4,354,768,983.08</b>	<b>9,461,944,216.92</b>	<b>31.5</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,816,713,200.00</b>	<b>4,354,768,983.08</b>	<b>9,461,944,216.92</b>	<b>31.5</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>13,694,619,600.00</b>	<b>4,232,675,383.08</b>	<b>9,461,944,216.92</b>	<b>30.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>258,993,600.00</b>	<b>245,949,141.00</b>	<b>13,044,459.00</b>	<b>95.0</b>
Үндсэн цалин	209,066,900.00	198,481,122.00	10,585,778.00	94.9
Нэмэгдэл	21,766,700.00	25,119,019.00	(3,352,319.00)	115.4
Унаа хоолны хөнгөлөлт	28,160,000.00	22,349,000.00	5,811,000.00	79.4
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,374,200.00</b>	<b>32,374,200.00</b>	-	<b>100.0</b>
Тэтгэврийн даатгал	22,014,500.00	23,050,848.00	(1,036,348.00)	104.7
Тэтгэмжийн даатгал	2,589,900.00	2,471,204.00	118,696.00	95.4
ҮОМШӨ-ний даатгал	2,071,900.00	1,846,405.00	225,495.00	89.1
Ажилгүйдлийн даатгал	518,000.00	455,067.00	62,933.00	87.9
Эрүүл мэндийн даатгал	5,179,900.00	4,550,676.00	629,224.00	87.9
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,487,400.00</b>	<b>36,359,963.00</b>	<b>10,127,437.00</b>	<b>78.2</b>
Гэрэл, цахилгаан	19,259,400.00	11,431,963.00	7,827,437.00	59.4
Байрны түрээс	27,228,000.00	24,928,000.00	2,300,000.00	91.6
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,609,964,800.00</b>	<b>1,333,304,685.00</b>	<b>4,276,660,115.00</b>	<b>23.8</b>
Бичиг хэрэг	6,500,000.00	7,184,450.00	(684,450.00)	110.5
Тээвэр, шатахуун	5,596,564,800.00	1,319,360,891.00	4,277,203,909.00	23.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,900,000.00	6,759,344.00	140,656.00	98.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>166,394,100.00</b>	<b>120,412,658.08</b>	<b>45,981,441.92</b>	<b>72.4</b>
Багаж, техник, хэрэгсэл	16,600,000.00	9,401,020.00	7,198,980.00	56.6
Тавилга	4,570,000.00	-	4,570,000.00	-
Урсгал засвар	145,224,100.00	111,011,638.08	34,212,461.92	76.4
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>1,186,000.00</b>	<b>3,814,000.00</b>	<b>23.7</b>
Дотоод албан томилолт	5,000,000.00	1,186,000.00	3,814,000.00	23.7
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,574,405,500.00</b>	<b>2,462,088,736.00</b>	<b>5,112,316,764.00</b>	<b>32.5</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,561,500,000.00	2,457,097,420.00	5,104,402,580.00	32.5
Даатгалын үйлчилгээ	4,000,000.00	3,985,656.00	14,344.00	99.6
Тээврийн хэрэгслийн татвар	540,000.00	540,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	240,000.00	99,000.00	141,000.00	41.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	-	132,000.00	-
Газрын төлбөр	7,993,500.00	366,660.00	7,626,840.00	4.6
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>	-	<b>100.0</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	-	100.0

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>ТАТААС</b>	<b>120,093,600.00</b>	<b>120,093,600.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>120,093,600.00</b>	<b>120,093,600.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	120,093,600.00	120,093,600.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>13,816,713,200.00</b>	<b>4,354,719,483.08</b>	<b>9,461,944,216.92</b>	<b>31.5</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,267,148,400.00</b>	<b>1,121,597,164.08</b>	<b>135,551,235.92</b>	<b>89.2</b>
Орон нутгийн төсвөөс	1,267,148,400.00	1,121,597,164.08	135,551,235.92	89.2
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>12,559,564,800.00</b>	<b>3,233,122,319.00</b>	<b>9,326,392,981.00</b>	<b>25.7</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	23,046,000.00	(13,046,000.00)	230.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	49,500.00	(49,500.00)	-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	12,549,564,800.00	3,210,076,319.00	9,339,488,481.00	25.6
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>39</b>	<b>39</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Удирдах ажилтан	2	2	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	18	18	-	100.0
Үйлчлэх ажилтан	19	19	-	100.0
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>39</b>	<b>39</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	20	20	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19	19	-	100.0

**4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>8,525,104,494.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>8,525,104,494.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		8,525,104,494.00
Хангамж, бараа материалын зардал		2,837,194,994.00
Тээвэр, шатахуун		2,837,194,994.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>2,161,049,500.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,161,049,500.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>3,526,860,000.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		3,526,860,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>8,525,104,494.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>8,525,104,494.00</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,525,104,494.00